



ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ЯАМ



# Тендерийн урилга

Огноо: 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр  
Зээлийн дугаар ба нэр: Зээл 3843/3844-MON: Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр – I үе шат  
Гэрээний дугаар ба нэр: БА01: Баянзүрх дүүргийн 17 дугаар хорооны өрхийн мэндийн төв (1)-ийн барилгын ажил  
Тендер хүлээж авах хугацаа: 2024 оны 2 дугаар сарын 2-ны өдөр

1. Монгол улс нь Азийн хөгжлийн банк (АХБ)-аас Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр - I үе шат төслийг санхүүжүүлэх зорилгоор энэхүү санхүүжилтийг хүлээн авсан бөгөөд уг хөрөнгөөр дээр дурдсан гэрээний төлбөрийг санхүүжүүлэх зорилготой болно. Тендер шалгаруулалт нь АХБ-ны эрх бүхий орны тендерт оролцогчдод нээлттэй байна.
2. Эрүүл мэндийн яам (“Захиалагч”) нь эрх бүхий тендерт оролцогчийг Баянзүрх дүүргийн 17 дугаар хорооны өрхийн эрүүл мэндийн төв (1)-ийн барилгын (“Ажил гэх”) ажлыг хийж гүйцэтгэх, дуусгах тухай битүүмжилсэн санал ирүүлэхийг урьж байна.
3. Нээлттэй өрсөлдөөнт тендер шалгаруулалт (дотоодод зарлан мэдээлэх)-ыг АХБ-ны *нэг үе шаттай: нэг дугтуйт* горимын дагуу зохион байгуулах ба тендерийн баримт бичигт заасан эрх бүхий орны бүх тендерт оролцогчдод нээлттэй байна.
4. Энэхүү тендер шалгаруулалтад зөвхөн дор дурдсан чадварын үндсэн шаардлагыг хангасан эрх бүхий тендерт оролцогч оролцоно. Үүнд:

- **Санхүүгийн үзүүлэлт:**

Тендерт оролцогчийн одоогийн санхүүгийн чадавхийг харуулах үүднээс сүүлийн 3 жилийн (2020, 2021, 2022) аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан, эсхүл тендерт оролцогчийн харьяа орны хуулиар аудитаар баталгаажуулахыг үл шаардсан бол захиалагчийн зөвшөөрөх бусад хэлбэрийн санхүүгийн тайланг илгээнэ. Тендерт оролцогчийн цэвэр хөрөнгийн доод хэмжээг нийт актив хөрөнгө ба нийт өр төлбөрийн зөрүүгээр тооцох ба энэ зөрүү нь ашигтай байна.

- **Барилгын ажлын жилийн дундаж борлуулалт:**

Сүүлийн 3 жилд (2020, 2021, 2022) хэрэгжиж байгаа эсхүл хэрэгжиж дууссан гэрээт ажлын хүрээнд хийгдсэн нийт баталгаат төлбөрийн дүнгээр тооцож гаргасан барилгын ажлын жилийн дундаж борлуулалтын доод хэмжээ **1,500,000,000** төгрөг байна.

- **Санхүүгийн нөөц хөрөнгийн шаардлага:**

Тендерт оролцогч нь одоо хэрэгжиж буй гэрээний үүргийн дүнг оруулаагүй хэмжээгээр **250,000,000** төгрөгийн санхүүгийн чадварын шаардлагыг хангах хүрэлцээтэй санхүүгийн нөөц хөрөнгөтэй байх.

- **Төрөл ба хэмжээгээр төстэй гэрээний туршлага:**

Сүүлийн 3 жилд (2020, 2021, 2022) амжилттай эсхүл үндсэнд нь гүйцэтгэж дуусгасан, санал болгож буй ажилтай дүйцэхүйц **1,200,000,000** төгрөгний өртөгтэй, нэгээс доошгүй гэрээт ажилд оролцсон байх.

• **Үндсэн үйл ажиллагааны барилгын ажлын туршлага:**

- (i) 700 мкв-аас багагүй талбай бүхий цутгамал төмөр бетон хийцлэлтэй барилга барьж байсан туршлагатай байх;
- (ii) Эмнэлгийн оношилгоо, эмчилгээний тусламж, үйлчилгээний халдваргүй, ариун орчныг бүрдүүлэхүйц өрөө, тасалгааны шинэчлэл засвар үйлчилгээ хийж байсан туршлагатай байх. Үүнд: эмнэлгийн үзлэгийн өрөө, лаборатори, ариутгал халдваргүйжүүлэлтийн өрөө, яаралтай тусламжийн өрөө, вакцинжуулалтын өрөө болон бусад

5. Дэлгэрэнгүй мэдээлэл авах болон тендерийн баримт бичигтэй танилцах сонирхолтой эрх бүхий тендерт оролцогч нь дараах хаягаар хандана:

**Захиалагч** : Эрүүл мэндийн яам  
**Харилцах ажилтан** : А.Юмчмаа, Төслийн худалдан авалтын ажилтан  
**Хаяг** : Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байрны өргөтгөл, Эрүүл мэндийн яам  
**Давхар/Өрөөний дугаар** : 3 давхар, 304 тоот  
**Хот** : Улаанбаатар хот  
**ZIP код** : 11000  
**Улс** : Монгол улс  
**Утасны дугаар** : +976 11 329369  
**Цахим шуудангийн хаяг** : [procurement2@hsdp.org](mailto:procurement2@hsdp.org)

6. Монгол хэл дээр боловсруулсан тендерийн баримт бичгийг авах хүсэлтэй тендерт оролцогч нь

- дээр дурдсан хаягт хандан **БА01: Баянзүрх дүүргийн 17 дугаар хорооны өрхийн эрүүл мэндийн төв (1)-ийн барилгын ажлын** тендерт оролцох тухай албан хүсэлт гаргах ба;
- үл буцаан олгох нөхцөлөөр **100 ам. доллар** эсвэл **350,000** төгрөгийн төлбөрийг доорх дансаар дамжуулан шилжүүлсэн байна:

<u>Гадаад шилжүүлэг</u>		<u>Дотоод шилжүүлэг</u>	
Payee's Name	: Improving Access to Health Services for Disadvantaged Groups Investment Program	Дансны нэр	: ЭБИЭМТҮХСХОХ МОН3843
Bank Name	: State Bank of Mongolia Ulaanbaatar, Mongolia	Банкны нэр	: Төрийн сан
Payee's Account No.	: 106000076051 (USD)	Дансны дугаар	: 100900011878 (MNT)
SWIFT Code	: STBMMNUB		
Corresponding Bank			
Bank Name	: Kookmin Bank		
SWIFT Code	: CZNBKRSE		
Account No.	: 7968USD019		

7. Тендерийг Монгол улс Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж 2, Засгийн газрын VIII байрны өргөтгөл, Төсөл хэрэгжүүлэх нэгжийн байр, 2 давхар, 203 тоот өрөөнд тендер хүлээн авах эцсийн хугацаа **2024 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 15 цаг 00 минутаас (Улаанбаатарын цагаар)** өмнө ирүүлсэн байна.
- Захиалагч тендерийн баримт бичгийн ТООЗ 23 дүгээр зүйлд заасан тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш ирүүлсэн аливаа тендерийг хугацаа хоцорсон гэж зарлан түүнээс татгалзаж, нээлгүйгээр буцаана.
  - Тендерийн баримт бичигт шаардсан тендерийн баталгааны хамт ирүүлнэ.
  - Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусмагц тендерийг нэн даруй нээх ба тендерт оролцогчдын төлөөллийг өөрсдийнх нь хүсэлтээр байлцуулна.
8. Захиалагч нь тендерт оролцогчийн тендер бэлтгэх, хүргүүлэхтэй холбогдсон аливаа зардлыг хариуцахгүй.